

## **ЭДИЙН ЗАСГИЙН ДИПЛОМАТ АЖИЛЛАГАА : ОНОЛ-ТҮҮХ, ОРЧИН ҮЕИЙН ЗАНГИЛАА АСУУДАЛД**

*Д. Уламбаяр\**

Эдийн засгийн дипломатын тухай асуудал нь Монгол Улсад харьцангуй бага судлагдсан, энэ утгаараа судалгааны шинэхэн чиглэл гэж хэлж болно. Тиймээс дурдсан чиглэлд судлаачид анхаарлаа хандуулдаг нь бүрнээ зүй ёсны хэрэг юм.

Дэлхийн эдийн засаг даяаршиж, улс орнуудын харилцан хамаарал улам бүр гүнзгийрч, хөгжлийн асуудал тэргүүн зэрэгт тавигдах болсон орчин үеийн шатанд дипломат ажиллагаанд худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, зээл, хөгжлийн тусламж, санхүү, мэдээллийн технологи, хүрээлэн буй орчин, экологийн асуудал шинэ үүрэг гүйцэтгэх болсон явдал юм.

Монгол Улс гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр хэрэгжүүлж байгаа нь эдийн засгийн дипломат ажиллагаанд онцгой ач холбогдол өгч байгаа хэрэг мөн.

### **Онол-арга зүйн үндэслэл**

Дэлхийд нэрд гарсан дипломатчид дипломат ажиллагааны талаар нийтэд хэдийн танил болсон өөрсдийн бүтээлүүддээ тодорхой авч үзсэн байдаг. Английн нэрд гарсан дипломатч Эрнест Сатоу өөрийн шилдэг “Guide to Diplomatic Practice” бүтээлдээ бичихдээ: “Тусгаар улсуудын Засгийн газрын хооронд, заримдаа харьяалалд нь байдаг улсуудтай албан ёсны харилцаа барихад хэрэглэх арга ухаан, эв дүй, бүр товчдоо энх тайвны арга хэрэгслээр улс хоорондын харилцаа явуулахыг дипломат ажиллагаа гэнэ”<sup>1</sup> гэсэн байна. Английн өөр нэг нэртэй дипломатч Харольд Никольсон “Diplomacy” бүтээлдээ: “дипломат ажиллагаа гэдэг бол яриа, хэлэлцээний замаар олон улсын харилцааг элчин сайд ба элчингээс зохицуулж явуулдаг арга барил, дипломатчийн ур чадвар юм”<sup>2</sup> гэжээ. Германы нэрд гарсан олон улсын эрх зүйч Г.Мартенс дипломат ажиллагаа гэдэг нь “төрийн гадаад харилцаа буюу төрийн гадаад хэргийн тухай шинжлэх ухаан, урлаг”<sup>3</sup> гэжээ. Колльерийн нэвтэрхий тольд “Дипломат ажиллагаа гэдэг нь Засгийн газруудын хооронд хэлэлцээ явуулах онол, практик” гэж тайлбарласан байдаг. ОХУ-ын олон улсын эрх зүйн толь бичигт энэхүү ойлголтыг тодорхойлохдоо: “олон улсын эрх зүйгээр зөвшөөрөгдсөн тусгай арга барилын тусламжтайгаар төрийн гадаад бодлогыг биелүүлэх хэрэглүүрийн нэг юм. Явцуу утгаараа бол олон улсын хэлэлцээ явуулах ур чадвар” гэсэн байна. АНУ-ын “Britannica”

\* Д.Уламбаяр - доктор, профессор

нэвтэрхий тольд “олон улсын харилцааг явуулах арга... хүч хэрэглэхгүйгээр улс үндэстэнд туйлын таатай нөхцөл бүрдүүлэх хэрэгсэл” гэж дипломат ажиллагааг томъёолсон байна.

Эдгээрээс үндэслэн “олон улсын харилцааг хүч хэрэглэх замаар бус, харин яриа, хэлэлцээний замаар, олон улсын эрх зүйд тулгуурлан явуулах ур чадвар, урлагийг дипломат ажиллагаа гэнэ” хэмээн товчоор томъёолдог ажээ.

“Гадаад бодлого”, “дипломат ажиллагаа” гэдэг нь агуулгаараа ялгаатай боловч харилцан нягт уялдаа бүхий хоёр ойлголт юм. Улс гүрэн гадаад харилцаандаа баримтлах ерөнхий чиг шугамыг гадаад бодлого хэмээх агаад, харин дипломат ажиллагаа гэдэг нь гадаад бодлогын зорилгыг хэлэлцэн тохиролцох, зөвшилцөх замаар хэрэгжүүлэх арга барил, ур чадвар юм.

Хуучин дипломатын үе болон хүйтэн дайны жилүүдэд дипломат ажиллагааны улс төр, үзэл суртлын хүрээ ялангуяа посткоммунист орнуудад шийдвэрлэх үүрэгтэй байв.

АНУ-ын олон улсын харилцааны онолч, геополитикч, профессор Ханс Моргентау гадаад бодлого, дипломат ажиллагааны үндсэн дөрвөн зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

*“1. Дипломат бодлого хуч чадавхи, бололцоондоо тохируулан өөрийн зорилтыг тодорхойлох ёстой,*

*2. Дипломат бодлого нөгөө улсынхаа зорилтыг тодорхойлох ёстой,*

*3. Дипломат бодлого хоёр улсын зорилт хоорондоо хэр авцалдаж байгаагаар тодруулах ёстой,*

*4. Дипломат бодлого дээрхид тулгуурлан өөрийн зорилтыг хэрэгжүүлэх аргыг зөв сонгох ёстой”<sup>4</sup>* гэжээ. Энэ нь гадаад бодлого, дипломат ажиллагаа, олон улсын харилцааны судалгааны чухал арга зүй мөн.

Дипломат ажиллагаанд олон улсын харилцаа, дэлхийн эдийн засгийн бодит байдал шууд тусгалаа олдог.

Өнөөгийн олон улсын эдийн засгийн харилцааны үндсэн шинжийг хураангуйлан дүгнэвэл:

- *дэлхийн эдийн засаг даяаршиж, бие биенээсээ улам бүр харилцан хамааралтай болж, ямар ч хүчирхэг эдийн засагтай улс, гүрэн ч өөрийнхөө хөгжил дэвшил, үндэсний аюулгүй байдлаа дангаараа хангаж, хөтлөн авч явах бололцоогүй болсон,*

- *олон улсын харилцаанд интеграцчлалын үйл явц шийдвэрлэх үүрэгтэй болж байгаа,*

- *олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт улам бүр хөнгөвчлөгдөж, ДХБ-аар зохицуулагдах болсон,*

- хөгжиж байгаа орнууд олон улсын банк, санхүүгийн байгууллага, их гурнуудийн тусламж, нөлөө ивээл, үндэстэн дамнасан бизнесийн бүлэглэлүүдийн хөрөнгө оруулалтад улам бүр дулдуйдах болсон нь тэдгээр орнуудын хөгжлийн асуудал, үндэсний аюулгүй байдлын тодорхой хэсэг дээрх байгууллага, улс, корпорациудаас олон талаар хамаарах болж байгаа,

- эдийн засгийн протекционизм нэг орны хүрээнээс хальж бус нутгийн хүрээнд шилжих болсон,

- зарчмын цоо шинэ үүрэгтэй болсон мэдээлэл, харилцаа холбооны технологийн үсрэнгүй хөгжилтэй уялдан орон зай, цаг хугацаа, эдийн засгийн шинжлэх ухааны тухай хуучин ойлголт үндсээрээ шинчлэгдэж байгаа,

- бус нутгийн интеграциуд өөр хоорондоо хамтын ажиллагаагаар холбогдож транс-континенталь шинж чанартай болж байгаа, үүний тод илрэл нь АСЕМ,

- үндэсний эдийн засаг дэлхийн зах зээлийн хуулиар зохицуулагдаж, үндэсний баялаг, түүхий эдийн нөөцөө захиран зарцуулах нь нэг улсын эрх мэдэл, хил хязгаараас шалтгаалахгүй, хүний эрх, үндсэн эрх чөлөө, ардчилалын асуудал нь дан гагц улс орны дотоод хэрэг биш, харин олон улсын шинжтэй бөгөөд олон улсын шийтгэлтэй болсон,

- байгаль-экологийн гамшиг, цаг уурын өөрчлөлт, олон улсын терроризм, уламжлалт бус шинэ өвчний тархалт глобаль эдийн засагт ноцтой уршиг тарих болсон,

- шавхагдашгүй биш болох нь тодорхой болсон манай гаригийн нөөц баялаг, хун амын өсөлт, хунс тэжээлийн хомсдол, өлсгөлөн, ядуурал нь глобаль шинжтэй болсон,

- Дэлхий нийгэд ардчилал хөгжиж байгаа боловч, сайн засаглал, тогтвортой хөгжил ихээхэн эмзэг, сул байгаа нь хамтын аюулгүй байдлын (хүний аюулгүй байдал) тогтолцоонд улам бүр сөрөг нөлөө үзүүлж буй,

- төв руу тэмүүлэх, төвөөс зугтаах хүчний аль аль нь үйлчилж буй даяаршлын эрин үед олон улсын эдийн засгийн шинэ дэг журам төлөвших үйл явцын төгсгөлийг төсөөлөх боломж тун бурхэг байгаа зэрэг санал, дүгнэлтүүд юм.

Тиймээс дэлхийн хамтын нийгэмлэг, улс орнуудын эдийн засгийн дипломат ажиллагааны өмнө томоохон зорилт, сорилт тулгарч байгаа нь тодорхой байна.

Эдийн засгийн дипломат ажиллагаа гэдэг нь улс хоорондын болон улс, бусад оролцогчдын хооронд явагдаж буй улс төр, худалдаа-эдийн засгийн харилцааг зохицуулах менежмент хийгээд маркетинг юм гэж Английн судлаач Николас Бейн, Стефен Уолькок нар “The

New Economic Diplomacy: Decision-Making and Negotiation in International Economic Relations” бүтээлдээ бичжээ.<sup>5</sup> Менежмент бол удирдлагын уян хатан, ур чадвар, урлаг бөгөөд маркетинг нь түншээ судлах, итгэн үнэмшүүлэх, өөрийн талд татах гэсэн үг ажээ.

Дипломат ажиллагаанд улс төрийн бодлого тэргүүлэх шинжтэй боловч, худалдаа-эдийн засгийн чиглэл тодорхойлох шинжтэй байх нь түүхэнд олонтой байсан бөгөөд даяаршлын эрин үед түүний ач холбогдол улам бүр өсөн нэмэгдэж байгаа нь бидний нүдний өмнө илт болжээ.

Дэлхийн II дайны дараа АНУ-ын Засгийн газар дипломат ажиллагааг “худалдаажуулах” эрчимтэй арга хэмжээ авснаар “trade diplomacy” гэсэн нэр томъёо гарчээ. Энэ нь эдийн засгийн дипломат ажиллагааны нэг хэсэг юм. Мөн “commercial diplomacy” гэсэн нэр гарсан нь цэвэр бизнес, арилжаатай холбоотойгоор улс, үндэстэн дамнасан олон улсын корпорациудын дэлхий даяар явуулж буй олон улсын маркетингийн бодлоготой холбоотой гэж хэлж болно.

Орчин үеийн эдийн засгийн дипломат ажиллагааны үндэс суурь чухамхүү АНУ-д тавигджээ. АНУ-ын эдийн засгийн дипломат ажиллагааны үндсэн зорилго нь **нэгд.** Дэлхийн эдийн засагтай нягт холбогдсон үндэсний эдийн засгийг макро, микро түвшинд зөв менежментээр удирдах, **хоёрт.** Америкийн үндэсний эрхэм дээд эрх ашгийг удирдлага болгон глобаль эдийн засгийн харилцаа, дэлхийн зах зээлийг зөв менежментээр удирдах, **гуравт.** АНУ-ын гадаад дахь худалдаа, хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрхийг тууштай хамгаалах, **дөрөвт.** Олон улсын эдийн засгийн харилцаан дахь тарифын болон тарифын бус саад тогторыг арилгаж, худалдаа, хөрөнгө оруулалтыг тууштай хөнгөвчлөх, **тавд.** Олон улсын аюулгүй байдлыг эдийн засгийн аргаар хангах, **зургаад.** Дэлхий дахинд АНУ-ын талаар зөв имиж бүрдүүлэх, **долоод.** Хүний эрх, ардчилал, сайн засаглал, зах зээлийн эдийн засгийг тууштай баримтлагч, олон улсын терроризмын эсрэг тэмцэгч улс орон, Засгийн газрыг бүх талаар дэмжих (жишээ нь: АНУ-ын Мянганы сорилтын сангийн буцалтгүй тусламж), **наймд,** Үл ташаагч орнуудын (цөмийн болон баллистик пуужингийн хөтөлбөр хэрэгжүүлж буй, хүний эрх, ардчилал, сайн засаглал сул, цэргийн дэглэмтэй, олон улсын терроризмийг зохион байгуулагч, өөгшүүлэгч, хил дамнасан зохион байгуулалтай гэмт хэрэг (тухайлбал: хар тамхи, зэвсгийн хууль бус наймаа, бохир мөнгө угаах, хүний наймаа г.м.) талаар дангаараа *embargo* болон НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн хүрээнд эдийн засгийн *veto* буюу хориг арга хэмжээ авах эдгээр болно. АНУ-ын эдийн засгийн дипломат ажиллагааг хэрэгжүүлэхэд Олон улсын хөгжлийн агентлаг (USAID) тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг.

Социализм системийн хувьд нуран унаж, хүйтэн дайн төгсгөл болсноос хойш АНУ дэлхий дээр жолоодогчийн үүрэг гүйцэтгэх тухай үзэл санаа бодлогын шинж чанартай болж байгаад лалын ертөнц болон бусад улс орон ихээхэн эгдүүцэн дургүйцэж байгаа тухай судлаачид, улс төрийн тоймчид онцлон тэмдэглэдэг. Үүнийг зарим улс гүрэн ганцаараа жанжлах гэсэн эрмэлзлэл гэж ч шүүмжлэх болсон нь онход оргүй зүйл бас биш юм. Харин ийнхүү дурьдаж байгаа нь хүйтэн дайны дараа үүсэн бүрэлдсэн олон туйлт бүтцийн үүргийг бодитой үнэлэх үндсэн дээр дэлхийд зохистой шинэ дэг журам тогтоох хэрэгт АНУ зонхилох үүрэг гүйцэтгэх чадавхитайг үгүйсгэж байгаа хэрэг биш гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Ямар ч тохиолдолд глобалчлалын эрин үед өрнө, дорно, исламын соёл иргэншлүүд тэвчээртэй байж, бие биеэ хүндэтгэн, энх тайвнаар зэрэгцэн орших нөхцөлд л улс төр, худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, соёлын харилцаагаа өргөн дэлгэр хөгжүүлж, илүү аюулгүй олон улсын харилцаа, олон улсын эдийн засгийн харилцааны шинэ дэг журмыг тогтоох боломжтой.

**Эдийн засгийн дипломат ажиллагаанд оролцогчид:**

Үүнд: - Улс,

- Улс биш оролцогчид:

Үүнд: - НҮБ, түүний системийн болон төрөлжсөн байгууллага,

- Интеграцийн байгууллага,
- Үндэстэн дамнасан корпораци, хувийн сектор,
- NGO (жишээ нь: Trilateral Commission)

**Эдийн засгийн дипломат ажиллагааны зарчим:**

Олон улсын эдийн засгийн харилцаа нь олон улсын эрх зүйн үндсэн зарчим, НҮБ-ын Дүрмийн зарчимд үндэслэн хөгжих ёстой. Үүнээс улбаалан эдийн засгийн дипломат ажиллагаанд дараах зарчим үйлчилнэ. Үүнд:

- Харилцан ашигтай байх зарчим;
- Преференцийн буюу хөнгөлөлтийн зарчим;
- Үндэсний нэн таатай нөхцөл олгох зарчим;
- Эдийн засгийн харилцаанд үл ялгаварлах зарчим;
- Үндэсний дэглэмийн зарчим;
- Гадаад худалдаа-эдийн засгийн харилцааны хэлбэрийг чөлөөтэй тогтоох эрхийн зарчим;
- Байгалийн нөөц баялгийг эзэмших бүрэн эрхийн зарчим;

- Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх зарчим эдгээр болно.

### **Эдийн засгийн дипломат бодлогын арга хэрэгсэл:**

- ❖ Хоёр талт хамтын ажиллагаа;
- ❖ Олон талт хамтын ажиллагаа;
- Улс төрийн;
- Эдийн засгийн;
  - Тарифын буюу эдийн засгийн протекционизм;
  - Тарифын бус арга хэмжээ;

### **Эдийн засгийн дипломатын гарал үүсэл, үйл явц, хөгжил**

Дипломат ажиллагаа анх үүсэх үед түүнд худалдаа тэргүүн зэргийн үүрэг гүйцэтгэж, дипломат ажиллагаа өөрөө худалдаанаас урган гарчээ гэж ОХУ-ын нэртэй дипломатч В.И.Попов “Орчин үеийн дипломат ажиллагаа: онол, практик” бүтээлдээ бичсэн нь буй.<sup>6</sup>

Түүхэнд эдийн засгийн дипломат ажиллагаа үндэсний эрх ашиг, аюулгүй байдалтай холбогдон ямар чиглэлээр, хэрхэн яаж, өрнөн хөгжиж ирснийг тэмдэглэх хэрэгтэй.

**АНУ-ын “нээлтэй хаалга”-ны бодлого** бол эдийн засгийн дипломат ажиллагаа мөн. 1899 оны намар АНУ Хятадад явуулах улс төр, эдийн засгийн цогц “нээлтэй хаалганы” бодлогыг зарлан тунхаглажээ. Энэхүү номлолыг АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жон Хей санаачлан, нэрт дипломатч, түвд судлаач Уильям Рокхилль боловсруулж, Конгрессоор батлуулан улмаар 1899 оны 9-11 дүгээр сард Англи, Герман, Франц, Хаант Орос, Япон, Италийн Засгийн газруудад ноотоор мэдэгджээ. “Нээлтэй хаалганы” бодлогын мөн чанар нь Хятад дахь их гүрнүүдийн ашиг сонирхол хоорондоо мөргөлдөхгүй байх, Хятадын газар нутаг, засаг захиргааны бүрэн бүтэн байдлыг хадгалах, худалдааны нөхцлийн талаар харилцан тэгш эрх эдэлж нэвтрэн ороход оршиж байв.

АНУ Номхон далайн орнуудад газар нутгийн сонирхолтой байсан бөгөөд Чин улс, Хятадын зүгт юуны өмнө худалдаа, эдийн засгийн сонирхол давамгайлж улс төр хоёрдугаарт тавигдаж байв. Америк нь бусад их гүрнүүдийн нэгэн адил Хятадын асар удам зах зээл, байгалийн баялаг, хямд ажиллах хүч, стратегийн байршилд анхаарлаа хандуулж байжээ.

1909 оны 12 дугаар сарын 14-нд АНУ, Манжуурын бүх төмөр замыг тухайлбал Дорнод Хятадын төмөр зам, Өмнөд Манжуурын төмөр зам хоёрыг “нийт дундын болгох” тухай Төрийн нарийн бичгийн дарга Филандер К.Ноксын төлөвлөгөөг зарласан нь хэрэг

дээрээ өөрийн хүчирхэг эдийн засагт түшиглэн, тэндээс Япон, Хаант Оросыг шахан гаргахад чиглэгдэж байв. Энэ саналыг Хаант Орос, Япон хоёр эс хүлээн авбал АНУ Цзиньчжоу-Айгуныгийн чиглэлээр төмөр зам тавихаар төлөвлөжээ. Ноксын төлөвлөгөөг Мүгдэн дэх АНУ-ын консул Виллард Стрейт улам тодотгон 1909 оны сүүлээр “Манжуур, Монгол болон Оросын Алс Дорнодод Америкийн эдийн засгийн хяналт тогтоох төлөвлөгөө” боловсруулан энэ асуудлаар Чин улсын Засгийн газартай хэлэлцээр хийж энэ тухайгаа Төрийн департаментдээ мэдээлж байсан байна.<sup>7</sup>

**“Долларын дипломат” бодлого:** XX зууны эхээр АНУ-ын өсөн нэмэгдэж байсан эдийн засгийн хүчин чадал дипломат бодлогод нь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж эхэлсэн байна. Өмнөх Ерөнхийлөгч Теодор Рузвельтын Засгийн газрын хүчээр түрий барих “гашуурын бодлогыг” “долларын дипломат” ажиллагаагаар үргэлжлүүснийг шинээр сонгогдсон Ерөнхийлөгч Уильям Тафт 1912 оны 12 дугаар сард Конгресст өргөн барьсан илгээлт нотлов. Уг илгээлтэд: “Одоогийн Засгийн газрын дипломат бодлого орчин үеийн худалдааны харилцааны шаардлагад зохицож байхыг шаардаж байна. Энэ бодлого нь доллар сэлэм, жадны үүргийг гүйцэтгэх ёстой” гэсэн байна. Сайхь бодлого нь хоёр талтай байсан агаад нэгд, гадаадад байрлуулсан Уолл Стритийн хөрөнгийг дипломат арга хэрэгслээр хамгаалах, хоёрт, хөрөнгө оруулалтын таатай нөхцлийг бүрдүүлэхэд ихээхэн анхаарч Уолл Стритийн доллараар АНУ-ын гадаад бодлого, дипломат ажиллагааг дэмжихэд оршиж байв. АНУ-ын Засгийн газар 1913 онд Хятад улсыг албан ёсоор хүлээн зөвшөөрсний зэрэгцээ тэнд Америкийн ашиг сонирхлыг бэхжүүлэх арга хэмжээ идэвхитэй авч хэрэгжүүлсэн байна. Ийнхүү У.Тафтын Засгийн газар худалдаа-эдийн засгийн гадаад харилцаа, гадаад дахь хөрөнгө оруулалтад анхаарлаа хандуулж байжээ.<sup>8</sup>

Ерөнхийлөгч Вудро Вильсон АНУ-ын банкуудаас Хятадын эдийн засгийг сэргээхэд зориулан хөрөнгө оруулалт хийхийг уриалж байсан нь чухамдаа долларын дипломат ажиллагааг гадаад бодлогын чухал зэвсэг гэж үзэж байсны нотолгоо юм. Дэлхийн I дайны сүүлчийн улиралд түүний Конгресст илгээсэн 14 зүйлт санаачилгад олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх, далайн тэнгист худалдааны флотын аюулгүй байдлыг найдвартай хангах тухай дэвшүүлсэн санаа нь АНУ-ын эдийн засгийн дипломат бодлогын илрэл болсон юм. Вудро Вильсоны санаачилга Версаль-Вашингтоны 1919-1922 оны бага хурал, Үндэстнүүдийн Холбооны ивээл дор болсон олон улсын эдийн засгийн асуудлаархи 1922 оны Генуягийн бага хурлын хэлэлцэх хэргийн хөтөлбөрт тусгалаа олсон ажээ.

**Бреттон вүүдсийн тогтолцоо (Trilateral systems of Bretton Woods):** Дэлхийн II дайны сүүлчийн улирал 1944 оны 6 дугаар сард АНУ-ын санаачлагаар Нью Хэмпшир муж улсын Вашингтон уулын аманд орших “Бреттон вүүдс” амралт, сувилалын газар дэлхийн 44 орны 300 гаруй төлөөлөгчид хуран чуулж, олон улсын худалдаа-эдийн засаг-валют, санхүү, зээлийн шинэ дэг журам тогтоох асуудлыг иж бүрэн хэлэлцэж үндсэнд нь шийдвэрлэсэн юм. Энэхүү түүхт бага хурлын дүнд АНУ-ын төслөөр ОУВС, ШХОУБ буюу Дэлхийн банк, ОУХБ/ГАТТ-ын үндэс суурь тавигдсан нь эдийн засгийн дипломат бодлогын түүхэн амжилт болсон юм. Дэлхийн II дайны төгсгөлд АНУ дэлхийн алтны нөөцийн бараг 80 хувийг эзэмших болсон нь 1934 онд Конгрессоор батлагдсан Алтны тухай хуульд 1 унц алтыг 35 ам.доллар байхаар заасныг ОУВС-гийн дүрэмд зүйлчлэн оруулснаар дэлхийн II дайны дараа ам.доллар олон улсын төлбөр, тооцооны гол, үндсэн валют болсон байна.<sup>9</sup> Энэ нь эдийн засгийн дипломат ажиллагааны шууд үр дүн байв.

**Маршаллын төлөвлөгөө:** АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жорж Маршалл 1947 оны 6 дугаар сард Харвардын их сургуулийн төгсөлтийн ёслол дээр Европыг сэргээн босгоход зориулсан хөтөлбөрөө зарласан юм. 1948-1952 оны хооронд Өрнөд Европын 17 оронд хэрэгжсэн 13 тэрбум ам.долларын өртөг бүхий (одоогийн ханшаар 250 тэрбум ам.доллар) Маршаллын төлөвлөгөөг хэрэгжүүлэх эрхзүй, зохион байгуулалтын механизмийг 1948 онд Европын Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Байгууллага нэртэйгээр үүсгэн байгуулжээ. Төлөвлөгөө хэрэгжиж, Өрнөд Европын орнуудын эдийн засаг сэргэн бэхжих явцад тэрхүү байгууллагыг өөрчлөн 1960 онд Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (Organization for Economic Co-operation and Development/OECD) болгон үйл ажиллагааны зорилго, агуулга, хүрээг нь өргөтгөсөн юм. Европыг сэргээн шинэчлэх энэхүү нүсэр төлөвлөгөөний мөн чанар, зорилго нь зах зээлийн эдийн засаг, ардчилалын үнэт зүйлсийг Европт бүх талаар бэхжүүлэх нь ирээдүйн АНУ-ын үндэсний эрх ашигт бүрнээ нийцэх учиртай байсанд оршино. Энэ нь АНУ-ын эдийн засгийн дипломат бодлогын гайхамшигт ялалт байсан гэж үзэж болно. Дурьдсан төлөвлөгөөнд ЗХУ, түүний холбоотнуудыг хамруулсан байсан боловч ЗХУ үүнийг Европыг капитализмжуулах хөтөлбөр хэмээн үзэж, түүнд оролцохоос татгалзаад зогсохгүй улмаар 1949 оны 1 дүгээр сард түүний эсрэг ЭЗХТЗ-ийг байгуулсан ажээ.<sup>10</sup>

**АНУ-ын “Lend lease act”:** Дэлхийн II дайн хүн төрөлхтний ХХ зууны түүхэнд гүн хар ул мөрийг үлдээсэн бөгөөд 4 тивийн хамарсан



билээ. Тэнхлэгийн орнуудын эсрэг дайнд оролцож байсан орнуудад АНУ-аас “Lend lease act” (түрээслэн зээлдүүлэх хууль)-ийн шугамаар өндөр өртөг бүхий тусламжийг үзүүлсэн байна. Дурьдсан хуулийн төслийг АНУ-ын Ерөнхийлөгч Франклин Д.Рузвельт 1941 оны 1 сард санаачлан, мөн оны 3 дугаар сард Конгресс баталсан ажээ. Хуулийн заалтаар 50 тэрбум ам.долларын зэвсэг техник, хүнс, түлш шатахуун, эм, эмчилгээний бараа бүтээгдэхүүнийг Берлин-Ром-Токиогийн тэнхлэгийн эсрэг байлдаж байсан орнуудад олгожээ. Үүний 60 хувь нь Англи, 20 хувь нь ЗХУ, 20 хувь нь Франц, Хятад, Австрали, Шинэ Зеланд, Энэтхэг, Турк, Исланд, Ойрхи Дорнодын орнуудад хуваарилагджээ. Гитлерийн Герман ЗХУ-д түрэмгийлэн довтолсны маргааш АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч С.Уэллес анх удаа Засгийн газрынхаа албан ёсны байр суурийг илэрхийлж мэдэгдэхдээ: Фашист Герман ЗХУ-д довтолсон явдал нь Америкийн ард түмний өмнө шинэ нөхцөл байдлыг буй болгосон бөгөөд учир нь Гитлерийн төлөвлөгөө нь дэлхий дахиныг эзлэн түрэмгийлэх зорилготой байгаа нь шууд уггаараа АНУ-ын аюулгүй байдал, үндэсний эрх ашигт нийцэхгүй юм гэжээ. ЗХУ удтал хэлэлцээ хийсний дүнд “Lend lease”-ийн хуулинд 1941 оны 10 дугаар сарын 1-нээс хамрагджээ. Зөвхөн Сталинградын дэргэдэх тулалдаанд Зөвлөлтийн зэвсэг техник, хүнс, түлш шатахуун, эмийн 35 хувь нь дээрх хуулийн дагуу нийлүүлэгджээ. Энэ хуулийн дагуу ЗХУ-д үзүүлсэн тусламжийн төлбөрийн асуудал 1972 оны 7 дугаар сарын Зөвлөлт-Америкийн Вашингтоны дээд хэмжээний уулзалтаар эцэслэн шийдвэрлэгджээ. “Lend lease act” нь АНУ-ын эдийн засгийн дипломат бодлогын бүрэлдэхүүн хэсэг байв.

**77 бүлгийн эдийн засгийн дипломат ажиллагаа:** Дэлхийн II дайны дараа Ази, Африк, Латин Америкийн 100 гаруй орон улс төрийн тусгаар тогтнолоо олж, 1960-аад оны эхнээс эдгээр улс орнууд эдийн засгийн тусгаар тогтнолоо бататгах зүгт шийдвэртэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XIX чуулганы тогтоолын дагуу 1964 оны 3 дугаар сард байгуулагдсан НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурлын (UNCTAD) анхдугаар чуулган дээр шинэ тулгар хөгжиж буй 77 орон олон улсын эдийн засгийн харилцаанд, тухайлбал хөгжингүй Умард, хөгжиж буй Өмнөдийн хооронд худалдаа-эдийн засгийн тэгш эрхийн засаглал тогтоох нэн чухал асуудлыг хамтын хүчин чармайлтаар шийдвэрлэхийг эрмэлзэж олон этгээдийн үндсэн дээр эдийн засгийн дипломат ажиллагаа явуулах шинэ үеийг нээснээр “77-гийн бүлэг” бий болжээ. Тийнхүү “77-гийн бүлэг”-ийн (2008 оны байдлаар 133 гишүүнчлэлтэй) санаачилгаар 1964

онд болсон НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурлаас гаргасан зөвлөмжийн дагуу хөгжингүй орнуудаас хөгжиж байгаа орнуудад преференцийн зарчим буюу худалдааны тарифын хөнгөлөлт үзүүлэх болсноор энэ зарчмын олон улсын эдийн засгийн харилцааны эрх зүйн эх үндэс тавигджээ. Энэ зарчмыг хөгжиж байгаа орнуудын хоорондын худалдааны харилцаанд ч өдгөө хэрэглэж байгаа юм.

ХЕС-ийн зорилго нь зээл, тусламж үзүүлэх замаар бус, харин худалдааг өргөжүүлэх замаар хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн юм.

ЮНКТАД-ын зарчим нь **“Trade is better than aid and loan”** буюу **“Худалдаа нь зээл, тусламжаас хавьгүй дээр”** гэсэн үг ажээ. Монгол Улс 1967 онд НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хуралд гишүүнээр элссэн бөгөөд харин “77-гийн бүлэг”-т 1989 оны 3 дугаар сард тус бүлгийн 25 жилийн ойг тохиолдуулан Венесуэль улсын нийслэл Каракас хотод болсон бага хурлаар гишүүн болжээ.

Хөгжиж байгаа орнууд дахь ядуурал, өлсгөлөн, хоцрогдлыг арилгаж, тэдгээрийн эдийн засаг-нийгмийн хөгжилд туслах нь бүх нийтийн эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилгод хүрэхийн чухал нөхцөл мөн.

ГАТТ-ын хүрээнд 1973-1979 онд үргэлжилсэн худалдааны олон талт хэлэлцээний Токиогийн үе шатанд “77-гийн бүлэг”. НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурлын идэвхтэй үйл ажиллагаа, санал санаачлагын үр дүнд 1974 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн ХХІХ чуулганы тусгай VI, VII хуралдаанаар “Олон улсын эдийн засгийн шинэ дэг журмын тухай Тунхаглал ба үйл ажиллагааны хөтөлбөр”, “Улс түмний эдийн засгийн эрх, үүргийн Харти” хэмээх нэн чухал хоёр баримт бичиг батлагдаж, түүнд: гадаад өрийн асуудлыг зохистойгоор шийдвэрлэх, хөгжиж буй орнуудад тэргүүний технологи чөлөөтэй нэвтрүүлэх, хүрээлэн буй байгаль орчныг хамгаалах, түүхий эд, ХАА-н бүтээгдэхүүний үнийг шударгаар тогтоох, худалдааны тарифын хөнгөлөлт үзүүлэх, хөгжиж байгаа орнуудын бараа бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гарахад нь саадгүй болгох, үндэстэн дамнасан корпорациудын үйл ажиллагаанд хяналт тавих, хөгжлийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх, олон улсын валютын системд шинэчлэл хийх, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, хамгийн гол нь олон улсын эдийн засгийн харилцаанд тэгш эрх, шударга ёс, харилцан ашигтай байх зарчмыг нэвтрүүлэх, гадурхлыг арилгах тухай тодорхой тусгагдсан байна.<sup>11</sup>

**Их долоогийн бүлгийн эдийн засгийн дипломат ажиллагаа:** Гол нь эрчим хүчний хямралтай холбоотойгоор 1975

оноос аж үйлдвэржсэн, ардчилсан орнуудын төр, засгийн тэргүүнүүд дотооддоо болон дэлхий дахинд тулгамдсан эдийн засаг, улс төрийн глобаль асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэхээр жил бүр хуран чуулдаг уламжлал тогтсон юм. 1975 оны 11 дүгээр сард Францын нийслэл Парисын ойролцоо Рамбуйе шилтгээнд болсон анхны дээд уулзалтад АНУ, Англи, Герман, Итали, Франц, Япон зэрэг зургаан орон оролцжээ. Улмаар 1976 оны Пуэрто Рикод болсон Сан Хуаны дээд хэмжээний хоёр дахь уулзалтаар Канадыг нэгтгэснээр Их долоогийн бүлэг бий болж, 1977 оны Лондоны уулзалтаар ЕЭЗХН-ийг өөртөө нэгтгэж хүрээгээ тэлсэн нь олон талт эдийн засгийн дипломат ажиллагааны шинэ хэлбэрийг буй болгож, эдүгээ Их наймын бүлэг болон өргөжиж дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргадаг байнгын механизм болов.<sup>12</sup>

**АСЕМ-ын эдийн засгийн дипломат ажиллагаа:** 1994 оны 7 дугаар сард ХБНГУ-ын санаачлагаар Европын Комисс **Шинэ Азийн бодлогын үзэл баримтлалаа** (Towards a New Asia Strategy) анх удаа боловсруулж гаргасан нь ч чухал ач холбогдолтой үйл явдал байв. 1994 оны 12 дугаар сарын Европын Холбооны Ессений дээд уулзалт дээрх баримт бичгийг бүрэн дүүрэн сайшаан дэмжижээ. Европын Холбооны Шинэ Азийн бодлогын үзэл баримтлал нь Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хөгжилд идэвхтэй хариу өгөх шаардлага байгааг тодорхой харуулсан юм.

*Шинэ Азийн стратеги өөд* баримт бичгээ баталсаны дараа Ази-Европын дээд хэмжээний уулзалт хийх санаачилгыг анх 1994 оны 10 дугаар сард Сингапурын Ерөнхий сайд Го Чок Тонг (Goh Chok Tong) Францад айлчлах үеэрээ гаргажээ.

Улмаар мөн оны 11 дүгээр сард АСЕАН-Европын Холбооны Гадаад хэргийн сайд нарын анхны уулзалтаар АСЕМ-ын үндэс суурийг тавьжээ.

Үүний үр дүнд АСЕАН-Европын Холбооны дээд уулзалт анх удаа 1996 онд Тайландын нийслэл Бангкок хотноо болсноор тив дамнасан интеграцийн хамтын ажиллагааны механизм АСЕМ буй болж АСЕМ-II 1998 онд Лондонд, АСЕМ-III 2000 онд Сөүлд, АСЕМ-IV 2002 онд Конпенхаген хотноо хуралдлаа. АСЕМ-V 2004 онд Ханой, АСЕМ-VI 2006 онд Хельсинк, АСЕМ-VII 2008 онд Бээжин, АСЕМ-VIII 2010 онд Брюссель хотноо болов.

Монгол Улс 2006 онд Хельсинкт болсон АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтаар Энэтхэг, Пакистаны хамт энэхүү олон талт хамтын ажиллагааны бүтцэд гишүүнээр элсэн орсон юм.

Дээд уулзалтад АСЕМ-ын гишүүд болох Европын Холбооны 27, АСЕАН-ы 10, Европын Комисс, АСЕАН-ы нарийн бичгийн дарга нарын

газар, БНХАУ, БНСУ, Япон, Монгол, Пакистан, Энэтхэг гэсэн нийт 43 гишүүн улсын Төрийн тэргүүнүүд, Ерөнхий сайд нар оролцжээ. Шинэ өргөжилтөөр АСЕМ нь 45 түншлэгчийг багтааж, түүнд дэлхийн ДНБ-ний 50 хувь, хүн амын 58 хувь, дэлхийн худалдааны 60 хувь нь ногдож байна.

**Их 20-ийн бүлгийн эдийн засгийн хамтын дипломат ажиллагаа:** Өнөөдөр дэлхийн хамтын нийгэмлэгийн улсууд нийгэм-улс төрийн хувьд зөрчилтэй, олон янз боловч бие биеэсээ улам их шалтгаалж, бие биедээ зайлшгүй шаардлагатай болж, олон талаараа бүхэл бүтэн нэгдмэл даяаршсан ертөнц юм. Өөр нэг илэрхий бодит байдал нь соёл иргэншлийн хувь заяанд амин чухал учир холбогдолтой дэлхий нийтийн түгээмэл асуудал буй болж хуримтлагдан хурцдаж байгаа явдал мөн. Тиймээс **Crisis management, урьдчилан сэргийлэх дипломат ажиллагаа (urgence diplomacy)**<sup>3</sup> гэж ихээхэн ярилцах болсон байна. 1999 оны Берлинд болсон Сангийн сайд нарын уулзалтаар үндэс суурь нь тавигдсан аж үйлдвэржсэн 19 улс орон болон Европын Холбоог нэгтгэсэн Их 20-ийн бүлэг 2008 оны зунаас эхэлсэн дэлхийн санхүү, эдийн засгийн хямралыг шийдвэрлэхээр мөн оны 11 дүгээр сард Вашингтон, 2009 оны 4 дүгээр сард Лондон, 9 дүгээр сард Нью Йорк хотноо өндөр дээд түвшинд хуран чуулж, үндэсний болон глобаль макро эдийн засгийг тогтворжуулах, улмаар өсөлтийг хурдасгах, олон улсын санхүүгийн институтийг шинэчлэх асуудлыг авч хэлэлцэн үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлж байгаа нь олон талт эдийн засгийн дипломат ажиллагааны чухал үр дүн болов. Их 20-ийн бүлгийн орнуудад глобаль эдийн засгийн үндэсний нийт бүтээгдэхүүний 85 хувь, дэлхийн худалдааны 80 хувь, хүн амын 3/2 нь ногдож байна.

Дэлхийн эдийн засагт байр суурь нь хэлбэрэлтгүй өсөн нэмэгдэж буй **BRIC**-ийн (Brazil, Russia, India and China) орнуудын эдийн засгийн хамтын дипломат ажиллагаа ч буй болж, түүнд 2011 оноос Өмнөд Африкийн БНУ нэгдснээр **BRICS** гэсэн шинэ бүтэц буй болов.

**Нефть-долларын бодлого ба ОПЕК:** Нефть-долларын бодлого бол эдийн засгийн дипломат ажиллагааны нэг төрөл гэж үзэж болно. Энэ бодлогын үндэс нь 1960 онд байгуулагдсан нефть экспортлогч орнуудын байгууллага ОПЕК-оос 1973 онд Өрнөдийн орнуудын эсрэг хар алтны үнийг огцом өсгөсөн явдал байв. 1960 онд 1 баррель нефтийн (гол нь саудын нефть) үнэ 2,4 ам.доллар байсан нь 1973 онд 34 ам.доллар болтлоо огцом өсчээ. ОПЕК экспортлох нефтийнхээ гадаад худалдааны үнийн талаар нэгдсэн бодлого явуулах болж, үнэ тогтоох асуудлыг бараг өөрийн мэдэлд бүрэн авсан байна. Араб-

Израилийн дайнаар Израилийг дэмжсэн Өрнөдийн эсрэг ОПЕК ийнхүү “хориг” тавьсан хэрэг байв. 1970-1980 оны хооронд нефть экспортлогчдийн цэвэр орлого 300 тэрбум ам.долларт хүрч, тэд капиталист ертөнцийн алтны нөөцийн 25 хувийг эзэмших болсон байна. Дэлхийн нефтийн экспортын бараг 90 хувийг эзэлдэг ОПЕК-ийн орнууд үнэ нэмэгдүүлэх арга хэмжээ авсан нь Өрнөдийн орнуудын төдийгүй хөгжиж байгаа орнуудын эдийн засагт хүнд цохилт болсон юм.<sup>14</sup>

**ОХУ-ын эдийн засгийн дипломат ажиллагаа** нь аанай л газрын тос, байгалийн хий зэрэг байгалийн баялаг, түүхий эдийн нөөцөд тулгуурласан борлуулалтын зах зээлийн төлөөх геополитик мөн болно. 2000 онд ОХУ-ын ДНБ дөнгөж 241.027 тэрбум ам.доллар байсан бол 2008 онд 1,676.586 тэрбум ам доллар болж даруй 6 дахин өссөн нь дээрх бодлогын шууд үр дүн юм. Өөрөөр хэлбэл 2000 онд ОХУ-ын ДНБ Өмнөд Солонгосынхоос 2 дахин бага байсан байна. Тэр онд Өмнөд Солонгосын ДНБ 421.069 тэрбум доллар байжээ.<sup>15</sup>

**БНХАУ-ын эдийн засгийн дипломат ажиллагаа** нь ардчилал, хүний эрхийн асуудлаас ангид нээлттэй хаалганы бодлого, “нэг улс, хоёр систем”, энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчим, асар том зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлаж байна. 1995 онд БНХАУ-ын ДНБ 649 тэрбум ам.доллар байсан бол 2009 онд 5,5 тэрбум ам.доллар болон өсч, Японы урд нэгэнт гарч, 15 их наяд ам.долларыг үйлдвэрлэдэг АНУ-ын дараа 2 дугаар байранд, валютын нөөц нь 3 орчим их наяд ам.долларт хүрч, дэлхийд тэргүүлж эхлэлээ.

ОХУ, Монгол Улсын холбоотны харилцаа үгүй болж, шинээр стратегийн түншлэлийн харилцааг тогтоосон хэдий ч Монголын “буфер улс”-ын гүйцэтгэдэг геополитикийн үүрэг хэвээр, нөгөө талд ХХI зуунд өмнөд хөршийн эдийн засаг үсрэнгүй хөгжих болсон нь сайхь улс геополитик, гео-эдийн засгийн нөлөөний хүрээгээ өргөжүүлэх өргөн боломжтой болж байгааг өрнөдийн судлаачид Хятадын «аюул» хэмээн нэрлэдэг нь ор үндэслэлгүй зүйл ч биш юм.

**БНСУ-ын Northern Diplomacy:** 1988 оны Сөүлийн зуны ХХIУ Олимп нь Өмнөд Солонгосын эдийн засгийн хөгжлийн гайхамшигийг “Хан мөрний гайхамшиг”, “Koreana” хамтлагийн «Hand in hand» олимпын дуугаар дэлхий дахинд харуулж чадсан билээ. Өрнөдийн судалгааны нэртэй төвүүд, санхүүгийн томоохон групп Голдмен Сакс, хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд шинээр аж үйлдвэржсэн Өмнөд Солонгос, Сингапур, Тайвань, Хонгконг зэрэг орнуудыг “Азийн дөрвөн бар” хэмээн нэрлэх болсон байна. БНСУ-ыг Умардаас ялгахын

тулд өрнөдийнхөн Өмнөд Солонгос хэмээн нэрлэж байсан бөгөөд 1970-аад оноос экспортын чиг баримжаатай эдийн засгийн бүтцийг буй болгож, үндэстэн дамнасан “Hyundai”, “Samsung”, “Daewoo”, “Lucky-Goldstar” зэрэг компаниуд нь дэлхийн зах зээлд гарч, АНУ, Япон, Өрнөд Европийнхонтой өрсөлдөх болсон юм. Тиймээс ч өрнөдийн хөгжингүй орнууд Азийн бар орнуудад худалдааны хөнгөлөлтийн системээ хүчингүй болгож эхэлсэн юм.

Өмнөд Солонгос ч Хойд Солонгосын хамгийн ойрын холбоотон социалист орнуудтай дипломат харилцаа тогтоож, олон улсын харилцаанд өөрийн улс төрийн байр сууриа бэхжүүлэх, Хойд Солонгосыг нээлттэй болгох, үндэсний нэгдлийг хэрэгжүүлэх, улам бүр өсөн нэмэгдэж буй эдийн засагт хэрэгцээтэй түүхий эд, борлуулалтын болон санхүүгийн шинэ зах зээл нээхийн тулд “умардын бодлого” явуулж эхэлжээ. Энэ бодлогын дүнд Дорнод Европын коммунист орнуудаас анхлан Унгар, дараалан Польш, ХБНСЮУ, Азийн коммунист орнуудаас БНМАУ анх удаа БНСУ-тай дипломат харилцаа тогтоох үйл явц эхэлж, тун удалгүй БНАСАУ-ын хамгийн ойрын холбоотон, хөрш ЗХУ, БНХАУ БНСУ-ыг албан ёсоор хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоосон нь Хоёр Солонгос нэгэн зэрэг НҮБ-д элсэх боломжтой болсон юм.<sup>16</sup> Өмнөд Солонгос бол Их 20-ийн бүлгийн гишүүн билээ.

**БНАСАУ-ын дипломат ажиллагаа** нь олон улсын тавцан дээр цөмийн болон пуужингийн хөтөлбөртөө дулдуйдан хөзөр тоглож, санхүү, эдийн засгийн томоохон хэмжээний тусламж авах явдал болно.

**Европын Холбооны эдийн засгийн дипломат ажиллагаа:** Олон улсын эдийн засгийн интеграци ХХ зууны сүүлийн хагас зуун жилд дэлхийн янз бүрийн бүс нутагт, ялангуяа Европт өрнөж ирсэн нь улс төр, эдийн засгийн гадаад, дотоод орчинг эерэгээр өөрчилж, улмаар орчин үеийн интеграцийн хамгийн боловсронгуй хэлбэр болох Европын интеграцийг үүсгэсэн байна. Тэр нь өргөжсөөр ирсэн төдийгүй, хөгжлийн харилцан адилгүй түвшинд байгаа улс орнуудыг хамрах болж, тив дамнасан интеграцийн үйл явц буюу хамтын ажиллагааны шинэ хэлбэрийг үүсгэв. Энэ нь Европын улс төр, эдийн засгийн философид гарсан цоо шинэ, чухал өөрчлөлт юм.

Европын Холбоо нь улс төрийн зорилгыг гэхээсээ илүү иргэдийн материаллаг аж байдал, сайн сайхан амьдралыг дээшлүүлэх эдийн засгийн зорилтыг гол чиг шугамаа болгодог либерал онолыг үндэс болгож, дэлхийг тусгаар улсуудын нийлбэр гэхээсээ илүү эдийн засгийн нэг цогц орон зай гэж үзэж, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ,

хөрөнгө, санхүү, ажиллах хүч, хүмүүсийг чөлөөтэй солилцох ёстой гэсэн байр суурь баримталсаар ирсэн нь томоохон үр дүнд хүрэв. Европын Холбооны хөгжлийн тусламжийн бодлого нь юуны өмнө өөрийн хуучин колони байсан орнуудад чиглэгдэж байсан юм.

Европын Холбоо 1994 онд баталсан **Шинэ Азийн үзэл баримтлалдаа** Монгол Улс газар зүй, геополитикийн чухал байрлалтай тул Европын Холбоо, түүний гишүүн орнууд Монгол Улстай улс төр, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх сонирхолтой байдгаа онцлон тэмдэглэсэн байна. Энэ байр суурь, хандлага нь Монгол орны байгалийн баялаг хийгээд Орос, Хятадын асар том зах зээлд нэвтрэн орох түшиц газар, түүнчлэн Монгол Улс Зүүн Азийн бүс нутгийг Европын Холбоотой холбож болох гүүр хэмээн Монгол Улсыг геополитик, геоэкономикийн үүднээс үзэж байгаатай холбоотой нь тодорхой байна.<sup>17</sup>

*Үргэлжлэл нь дараагийн дугаарт*

**ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ**

1. Satow Ernest, Guide to Diplomatic Practice. *London, New York, 1979, p.1*
2. Nicholson Harold, Diplomacy. *Washington D.C., 1988, p. 4-5*
3. Satow E, p.1
4. Morgenthau Hans J. Politics Among Nations: The Struggle for Power and Peace. *N.Y., Seventh edition. 2006, pp. 539-540*
5. Bayne N, Woolcock S, The New Economic Diplomacy: Decision-Making and Negotiation in International Economic Relations. *Second Edition, L., 2007, p.5*
6. Попов И.В. Орчин үеийн дипломат ажиллагаа: онол, практикийн асуудал. *УБ., 2007, 91 дэх тал*
7. Уламбаяр Д. Монгол Улс, Өрнө дахин: харилцаа, хамтын ажиллагаа. *УБ., 2007, 22-23 дахь тал*
8. Дипломатический словарь. *М., 1984, Том I, с. 154-155*
9. Spero Jaon E, Hart Jeffrey A, The Politics of International Economic Relations, *Sixth ed., NY., 2003, p.14*
10. Spero Joan...p. 185
11. Spero Joan...p. 185
12. Fred Bergsen, Randall Henning C, Global Economic Leadership and The Group of Seven *N.Y., 1996, p.89*
13. Dent, Christopher M., The European Union and East Asia: Geoeconomics, Economic Diplomacy and Crisis Management. *2d ed. London, 2009, p. 25*
14. Дипломатический словарь. *М., 1984, Том I, с.265*
15. World Development Indicators: 2009, World Bank Atlas, *pp. 46-47*
16. Kim Hak-Joon, Korea's Relations with her Neighbors a Changing World, *Seoul., 1995, p. 21-25*
17. Commission of the European Communities, Communication from the Committee to the Council "Towards a New Asia Strategy", COM (94) 374 Final, *13 July 1994*